



Г.АЗЖАРГАЛ: Нөхөн төлүүлсэн хохирлын хөрөнгө мөнгийг АТГ захиран зарцуулдаггүй

Шүгэл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Төрийн ордонд хэвлэлийн бага хурал хийх үеэр АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал сэтгүүлчдийн асуултуудад дараах хариултыг өгөв.

Гэмт хэргээс хурааж авсан хөрөнгийг хэрхэн ашиглахыг заах эрх зүйн орчин АТГ-т байдаггүй. Хураагдсан болон битүүмжлэгдсэн хөрөнгийг захиран зарцуулах тухай хуулийн төсөл явж байгаа.

АТГ-аас шалгаад нөхөн төлүүлж буй хөрөнгө, мөнгө нь хохирогчид очдог. Хохирогч хэн байдаг вэ гэвэл, зарим тохиолдолд төрийн өмчит компаниуд, улсын дансанд ордог. Нөхөн төлүүлсэн хөрөнгө юунд зарцуулагдахыг бид заах эрхгүй.

Манай байгууллага:

- 2017 онд 3.4 тэрбум төгрөг
- 2018 онд 11.9 тэрбум төгрөг
- 2019 онд 11.3 тэрбум төгрөг
- 2020 онд 35.6 тэрбум төгрөг
- 2021 онд 96.2 тэрбум төгрөг
- 2022 онд 2.2 их наяд төгрөгийг нөхөн төлүүлсэн.

Шүгэл үлээгчдийн эрх зүйн байдлын тухай хуулийг салбар яаманд хүргүүлсэн ба олон зүйлийг зааж өгсөн. Зөвхөн улс төрд нөлөө бүхий этгээдийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхийг хориглосон. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хууль болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай тэмцэх хуульд улс төрд нөлөө бүхий этгээд гэж хэн болохыг нарийн заасан. Өргөдөл гомдол мэдээллээ нэрээ нууцалж өгөх үү, ил байдлаар өгөх үү гэж асуудаг. Аль ч хэлбэр нь нээлттэй. АТГ-т 2022 онд 2,196 гомдол ирсэн нь өндөр тоо юм.

Эх сурвалж: www.ikon.mn

Нүүрсний гэх тодотголтой хэргийн мөрдөн шалгах ажлын явцын мэдээлэл

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Тавантолгойн бүлэг орд газраас “Эрдэнэс Тавантолгой” ХК болон орон нутгийн өмчит “Тавантолгой” ХК-д нүүрс олборлох, тээвэрлэх, борлуулах, улсын хилээр нэвтрүүлэх, төмөр замын бүтээн байгуулалт, барилгын ажил гүйцэтгэх, тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаанд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал бий болгосон, хахууль авсан, мөнгө угаасан, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хэргүүдэд ажлын хэсгээс мөрдөн шалгах ажиллагааг явуулж буй.

Одоогийн байдлаар хэрэг бүртгэлтийн 25, мөрдөн байцаалтын 17 буюу нийт 42 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Энэ хугацаанд хил хамгаалах байгууллага, гааль, АТҮТ-ийн эрх бүхий албан тушаалтнууд нь хууль бусаар гаалийн бүрдүүлэлтгүй тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлж, хахууль авсан, олон улсын ачаа тээврийн С зөвшөөрөл олгохдоо бусдаас хахууль авсан зэрэг нийт 42 яллагдагчид холбогдох гурван хэргийн мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж, шүүхэд шилжүүллээ.

Эд мөрийн баримтыг илрүүлэх зорилгоор нэгжлэг хийх ажиллагааг 166 объектод, хүний бие, эд зүйл баримт бичигт үзлэг хийх ажиллагааг 407 удаа, 1,032 хүнээс гэрчийн мэдүүлэг авч, хөрөнгийн үнэлгээ хийх ажиллагааг 25 удаа, байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс 973 удаа баримт гаргуулан авах ажиллагааг явуулсан.

Өнгөрсөн хугацаанд 85 албан тушаалтанд эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татсан бөгөөд үүний 48 нь нийтийн албан тушаалтан байна.

Эдгээрээс 24 албан тушаалтныг эрх мэдлээ урвуулан ашигласан, 14 албан тушаалтан хахууль авсан, 26 албан тушаалтныг хахууль өгөх, 21 албан тушаалтныг мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэгт яллагдагчаар татсан байна. Одоо шалгаж буй хэрэгт 8 яллагдагч цагдан хоригдож байгаа.

Улсын хилээр гаргахыг хязгаарласан 41, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлсэн 4, хувийн баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээг 26 яллагдагчид авсан байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад одоогоор

- Үл хөдлөх хөрөнгө 94
- 48 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн
- Таван газар
- Хоёр хуулийн этгээдийн хувьцаа
- 35 иргэн 40 хуулийн этгээдийн арилжааны банк дахь зарлагын гүйлгээ
- Дөрвөн иргэний 3.2 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий үнэт цаасны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлаад байна.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

БНХАУ-аас суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруйг хүлээн авч уулзав

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруйг хүлээн авч уулзлаа.

Элчин сайд ноён Цай Вэньруй Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллахаа илэрхийлж, ижил чиг үүрэг бүх байгууллагуудын хамтын ажиллагааг улам хөгжүүлэн ажиллахаар тохиролцов.

Энэтхэг Улсын Элчин сайд Мохиндер Пратап Сингхийг хүлээн авч уулзав

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Мохиндер Пратап Сингхийг хүлээн авч уулзав.

Талууд цаашид Энэтхэг улсын ижил төстэй байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлэх, Авлигатай тэмцэх газрын албан хаагчдыг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцов.

АНУ-ын Төрийн Департаментын Иргэний аюулгүй байдал, ардчилал болон хүний эрхийн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн даргын орлогч Узра Зеятай уулзав

Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа АНУ-ын Төрийн Департаментын Иргэний аюулгүй байдал, ардчилал болон хүний эрхийн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн даргын орлогч, эрхэмсэг хатагтай Узра Зеяа-г хүлээн авч уулзав.

Эрхэмсэг хатагтай Узра Зеяа Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг өндрөөр үнэлж авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлд ихээхэн үр дүнтэй ажиллаж байгааг магтан сайшааж, Монгол Улсын ардчилал, эрх чөлөөг баталгааж урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжихэд авлигатай тэмцэх ажиллагаа нэн чухал ач холбогдолтойг дурдаж энэ хүрээнд Авлигатай тэмцэх газартай бүхий л салбарт тогтвортой хамтран ажиллахыг илэрхийлэв.



Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын төлөөлөгчтэй уулзав

Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар З.Баасанням, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Ихмөрөн нар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын Эдийн засаг, хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн зохицуулагч Игли Хасаниг хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө орлогын мэдүүлэг хянан шалгах, авлигын гэмт хэрэг мөрдөн шалгах чиг үүрэгтэй албан хаагчдыг сургах, гадаад улсаас хөрөнгө буцаах чиглэлд харилцан туршлага солилцож, хамтран ажиллахаар тохиролцов.

НЭГ ӨГҮҮЛБЭРЭЭР

- АТГ-ын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайдын яаманд очиж, эмгэнэлийн дэвтэрт гарын үсэг зурав.
- Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны 2022 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулах ажлыг амжилттай зохион байгуулснаар улсын хэмжээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны 124 байгууллагын 49678 албан тушаалтан мэдүүлгээ гаргаж баталгаажууллаа.
- Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах хүрээнд “Боловсрол хамтын ажиллагааны нийгэмлэг” ТББ-тай хамтран “Шударга ёсны боловсрол” сургалтыг Төв аймгийн “Хүмүүн” сургууль, 4, 5 дугаар сургуулийн 31 багш, 30 суралцагч, нийт 61 хүнийг хамруулан зохион байгуулав.
- “Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг-9” чадавх бэхжүүлэх сургалтад оролцож буй 21 аймаг, 9 дүүрэг, яам, агентлагийн төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн 310 албан тушаалтанд авлигын эсрэг сургалт зохион байгуулав.
- АТГ-аас явуулсан хяналт шалгалтын дүнд цаашид авлигын гэмт хэрэг, зөрчил үүсгэхгүй, албан тушаалтнуудын ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх, төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн хөрөнгийг үр ашигтай төсөвлөн зарцуулж байх чиглэлээр албан зөвлөмжийг Налайх дүүргийн ИТХ-ын дарга П.Нарантуяад хүргүүллээ.
- Авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд нийгмийн сүлжээнд түгсэн мэдээллийн мөрөөр хяналт шалгалтын ажил явуулж, АТҮТ-ийн удирдах албан тушаалтнуудтай уулзаж, цаашид хүний нөөцийн бодлого, албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах, Авлигын эсрэг хуульд заасны албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх гэж заасныг мөрдөж ажиллах талаар анхааруулж ярилцав.

Бар жилийн баярламаар мэдээ

Усан бар жилд олон үйл явдал тохиолоо. Онцолж энэхүү нийтлэлд авлигын эсрэг үйл ажиллагааны талаар өгүүлнэ.

2021 оны зунаас Засгийн газар авлигын эсрэг ажлын хэсэг байгуулснаа зарласан. Энэ хөтөлбөр бодит ажил хэрэг болж, бар жилийн туршид үргэлжлэв. Өмнө нь ийм дорвитой хөдөлж байсан Засгийн газар байсангүй. Улмаар бар жилд ирэх туулай жилийг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, “Таван Ш” хэмээх авлигатай тэмцэх шинэтгэлийн хөтөлбөр дэвшүүллээ. Авлигын эсрэг дан гагц АТГ тэмцэх нь хангалтгүйг өнгөрсөн 15 жилийн хугацаанд монголчууд сайтар мэдэж авлаа. Хууль эрх зүйн орчинг сайжруулах, тогтолцоог өөрчлөх чиглэлд яах ч аргагүй төр, засгийн түвшинд шийдвэр гаргагчдын бодит оролцоо, хамтын дэмжлэг хэрэгтэйг сайтар ойлгож авлаа. Авлигатай тэмцэх нь улс төрийн хүсэл зоригийн томоохон илэрхийлэл байдгийг олон улсын судлаачид удаа дараа хэлж мэдэгдсээр байгаа. Дутуу дундуур хуультай мөртлөө авлигатай тэмцэхийг АТГ-аас шаардах нь шүүр өгөөгүй атлаа хогоо шүүрд гэхтэй адил өрөөсгөл ойлголт. Шүдгүй арслангийн үлгэр гэсэн үг.

Харин энэ засгийн өнгөнд авлигатай тэмцэх ажлыг тогтолцооных нь түвшинд авч үзэж эхэлж байна. Энэ бол тун сайшаалтай хэрэг. Улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж байгаа нь өөрөө олзуурхан тэмдэглэх явдал. Нэгэнт улс орны өөдлөн дэвжихийн ганц гацаа нь авлига учраас, гацаанаас гаргах голгогцоо нь авлигыг бууруулах учраас, авлигаас ангижиръя гэвэл нийгмийн тогтолцоог бүхэлд нь засаж өөрчлөх ёстой учраас, үүний тулд хамгийн түрүүнд хууль эрх зүйн орчинг төгс болгох шаардлагатай учраас улстөрчдийн авлигатай тэмцэх хүсэл зориг магнайд нь туг мэт намирах учиртай юм.

Хэдийгээр эрх зүйн орчин дутуу дулимаг ч гэсэн АТГ яг одоо үйлчилж буй хуулийн орчинд амжилттай, үр дүнтэй ажиллаж байгааг энэхүү нийтлэлд цохон тэмдэглэхийг хүслээ. Энэ удаад зөвхөн мөрдөн шалгах ажлын зарим тоон үзүүлэлтийг дурдъя. Бар жилийн баярламаар олон мэдээний нэг нь яах аргагүй энэ мөн.

2019 оны гахай жилээс АТГ-ын мөрдөн шалгах ажил эрчимжиж, 2020 оны хулгана жилд үр дүн өмнөхөөс ахиж,

2021 оны үхэр жилд улам нэмэгдсэн бөгөөд 2022 оны бар жилд үсрэлттэй өссөн байна.

Дээр дурдсан дөрвөн оныг нийт дүнгээр нь авч үзвэл, АТГ-ын мөрдөн шалгах ажлын үр дүнд авлигаас учирсан 2 их наяд 443 тэрбум төгрөгийн хохирлыг улсад нөхөн төлүүлсэн байна. Энэ бол зөвхөн мөрдөн шалгах ажлын явцад нөхөн төлүүлсэн дүн.

Үүний дараа битүүмжлэн хамгаалсан хөрөнгийн хэмжээ бас яригдах ёстой. Битүүмжлэн хамгаалсан хөрөнгө гэдэгт авлигын гэмт хэргийн улмаас хураагдсан, битүүмжлэгдсэн хөрөнгийг хамруулдаг бөгөөд шүүхийн шийдвэрээр хохирол нөхөн төлүүлэх нөхцөлийг хангаж буй нэг хэлбэр юм. Сүүлийн дөрвөн жилд 1 их наяд 647 тэрбум төгрөгийн хөрөнгө, бэлэн мөнгийг АТГ битүүмжлэн хамгаалсан байна. Эдгээрийн хэчнээн нь улсад буцаагдаж төлөгдсөнийг уншигч Та шүүхийн шийдвэрийн сангаас үзэхэд нээлттэй.

2019-2022 онд авлигын гэмт хэргийн улмаас нийт 30 их наяд 2 тэрбум төгрөгийн хохирол улс нийгэмд учирчээ. Тэгэхээр 30.2 их наяд төгрөгөөр үнэлэгдэх хэмжээний хохирол бүхий авлигын гэмт хэргийг АТГ-ын мөрдөгчид илрүүлсэн байна

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажлын үр дүнг илэрхийлэх бас нэг тоо нь учирсан хохирлын хэмжээ байдаг. Жил тутам хохирлын хэмжээ нэмэгдсээр байгаа. Энэ нь нэг талаас авлигын гэмт хэрэг өссөөр байгааг харуулж буй ч нөгөө талаас харвал үйлдэгдсэн авлигын гэмт хэргийн илрүүлэлт сайн байгаагийн илрэл юм. Өөрөөр хэлбэл, ийм их хэмжээний авлигын гэмт хэргийг АТГ илрүүлж чадсан гэсэн үг.

2019-2022 онд авлигын гэмт хэргийн улмаас нийт 30 их наяд 2 тэрбум төгрөгийн хохирол улс нийгэмд учирчээ. Тэгэхээр 30.2 их наяд төгрөгөөр үнэлэгдэх хэмжээний хохирол бүхий авлигын гэмт хэргийг АТГ-ын мөрдөгчид илрүүлсэн байна.

Ер нь бол жил жилээр өссөн тоонуудыг энэ маягаар дурдаад хэлэхэд амархан. Дээр дурдсан их наядад яригдах тоонууд дотор гадаад дахь оффшор бүсээс авчирсан болон хахуульд өгөхөөр зэхэж байсан мөнгийг хурааж авсан ажил багтана. Тоонуудын цаана хэчнээн их

хөдөлмөр, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа, хил дамнасан яриа хэлэлцээ, мөрдөгчийн тактик, ур чадвар, өндөр гүйцэтгэл байгааг энд бүгдийг бичих аргагүй.

Илрүүлэлт сайн байхын зэрэгцээ шийдвэрлэлт мөн өссөөр байгааг дурдах ёстой. АТГ сүүлийн дөрвөн жилд 5458 гэмт хэрэг шалгаж шийдвэрлэсэн. Нэг жилд 1400 орчим авлигын хэрэг тогтмол шалгагдаж байна гэсэн үг.

Түүнчлэн авлигын гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо жил тутам өссөөр байгаа. 2019 онд 894 байсан бол улам бүр өссөөр 2022 онд 1841 болж эрс нэмэгджээ. Сүүлийн дөрвөн жилд нийтдээ гэмт хэргийн шинжтэй 5351 гомдол АТГ-т хаяглагдан ирсэн байна. Гомдол, мэдээллийн тоо ийнхүү өссөөр байгаагийн цаана буруу зөрүү бүхнийг энэ байгууллага шийдвэрлэж чадна гэх олон нийтийн итгэл баттай оршин буйн илрэл юм.

Ийнхүү туулай жилийн босгон дээр

өнгөрсөн оныг эргэцүүлж, уншигч Танд хэдэн тоо танилцуулав. Бар жилийн баярламаар мэдээний нэгээр АТГ-ын мөрдөн шалгах ажлын зарим тоон үзүүлэлтийг онцоллоо. Засгийн газраас дэвшүүлсэн “Таван Ш” хөтөлбөрийн үр дүнд Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийг баталж, орлогоосоо давсан хэрэглээтэй төрийн албан хаагчдыг илрүүлж, гадаад улс руу оргон зайлсан этгээдүүдийг эргүүлэн авчирч, оффшор бүсэд нуусан эд хөрөнгийг улсад буцааж, төрийн өмчит компанийн засаглалыг нээлттэй болгоход төр, засаг, хууль сахиулах байгууллага болон иргэд олон нийтийн оролцоо нэн чухал.

Авлига нь улс орны хэмжээнд нийтээр тулгарсан бодит аюул тул үүнтэй тэмцэхэд хүн бүрийн оролцоо, дэмжлэг хэрэгтэй. Бар жилийн баярламаар мэдээг өртөөлж туулай жилдээ илүү их үр дүнг баталгаажуулан бэхжүүлэхийн төлөө хамтаараа хичээцгээе.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ТАЛААР ХЭВЛЭЛИЙН ХУУДАСНАА



**ОДОО Л БИД
АТГ-ЫН ЗҮГ
ӨӨР НҮДЭЭР
ХАРАХ ЦАГ**

Сэтгүүлч
Б.ГАНЧИМЭГ


...Авлигын томоохон гэмт хэргүүдийг илрүүлж, албан тушаалтнуудыг шалгаад эхлэнгүүт ямар уриалгуудыг ил далд явуулж эхэлдэг вэ. Манай эрх мэдэлтнүүд ичиж нэрэлхэх юмгүйгээр л “АТГ-ыг татан буулгая” гээд улаан байм хашгирч эхэлдэг. Одоо ч тэгцгээж л байна. Үнэндээ улс төртэй бодлогоо нураалгахгүйн тулд “нүүж” байхад нь нийлж байна гэж харж байсан, хардаж байсан үе надад лав олон байжээ. Амаргүй, тал талаас шахуулсан хүнд үеүд энэ олон жилд бишгүй л тохиолдсон.

Ямар үед хулгайч нар ингэж бачимдан дайрдаг вэ. Тэгэхдээ хаашаа дайрдаг вэ гэдгийг сүүлийн жилд өрнөж буй авлигатай хийж буй “дайн”, хулгайтай тэмцэж байгаа тэмцэл бидэнд илүү тод томруун харуулж байна. Ингэж олж хартлаа, ойлготлоо харин бид маш их хугацаа алдчихаж. Одоо л бид АТГ-ын зүг өөр нүдээр харах ёстой цаг ирээд байна.

“АТГ-ыг татан буулгая, удирдлагыг нь солиод байя, хуулийг нь сулруулья” гэж тэс хөндлөн орилох тусам энэ чиглэлийн ажлын эрч л буурна. Энэ хэнд ашигтай вэ. Харин ч АТГ-ыг татан буулгах биш бүх аймгуудад салбартай болгож, орон тоог нь нэмэх хэрэгтэй юм биш үү. Жилдээ 2,3 их наядын хохирол барагдуулж байгаа энэ газрын ажлын үр дүнг ч илүү шударга тооцооллоор тооцож үзэх ёстой юм биш үү. Одоо л бид энэ байгууллагыг гаднаас нь “нүдэх”-ээс өөр нүдээр хармаар байна. Одоо...

Эцэст нь хэлэхэд авлигагүй болохын тулд бид юу хийх ёстой вэ. Авлигатай бүх нийтээрээ тэмцэх ёстой. Улс төрийн намуудынх нь санхүүжилт шилэн болох ёстой, сонгуульд нэр дэвшигчид санхүүжилтээ ил тод байлгах, Төрийн өмчит компаниудын засаглалыг сонгодог утгаар нь хийх гээд олон ажлуудыг цогцоор нь хийх ёстой. Ганцхан АТГ-ын нуруун дээр үүрүүлчихээд дуртай үедээ чулуугаар нүүлгээд сууж байж болохгүй нь ээ.

www.baabar.mn



**АВЛИГАЧДЫН
АЛСРУУЛСАН
ХӨРӨНГИЙГ
АВЧРАХ ЗАМ
ДАРДАНГҮЙ**

Сэтгүүлч
Г.ЦОЛМОН

Авлигачдын гадаадад нуусан хөрөнгийг АТГ улсдаа эргүүлэн авах ажиллагааг амжилттай явуулж, өнгөрсөн онд л гэхэд Англиас нэг орон сууц, 1.8 тэрбум төгрөг бэлнээр, 269 сая төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө хоёрыг буцаан авчраад буй. Мөн Британийн Виржинийн арлаас 2.2 тэрбум төгрөг буюу 1.6 сая ам.долларын үнэ бүхий газар, үл хөдлөх хөрөнгийг улсын өмчид бүртгүүлсэн, Мөн арлаас 11.3 тэрбум төгрөг буюу 5.7 сая ам.доллар улсын орлого болгон хураан авчээ.

Авлигачдын энэ мэтээр алсруулсан хөрөнгийг буцаан авах ажиллагаа явуулахад зам нь дардангүй, саад тотгор ихтэй байдаг аж. Нийгмийн сайн сайханд зориулагдах ёстой хөрөнгийг гадаад руу гаргаж нуусан үйлдлийг илрүүлж, ямар шат дамжлага туулан, цаг хугацаа зарцуулан буцааж авчирдгийг хүмүүс төдийлөн мэддэггүй.

Сүүлийн жилүүдэд АТГ хөрөнгө буцаах ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байна. Эрх зүйн талаар харилцан туслалцах гэрээгүй орнууд буюу оффшор бүсээс авлигын гэмт хэргийн улмаас гарсан хөрөнгийг буцаах ажиллагаа үр дүнтэй болсон нь АТГ гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлснийх.

“Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга”, ФАТФ зэрэг олон улсын байгууллагатай хамтарч, гадаад оронд нуун далдалсан авлигын гаралтай хөрөнгө, орлогыг угаах ажиллагааг зогсоох, алдагдсан хөрөнгийг буцаан авчирдаг. Ингэхдээ хөрөнгө буцаан авах хүсэлт, үндэслэлээ ул суурьтай гаргаж тавих ёстой. Хүсэлт хүргүүлэхдээ гадаад орны хамтын ажиллагаатай байгууллагынхантайгаа нягт холбоотой байж, “чихнээс нь хонх уяхгүй” бол хариу ирүүлэх нь удаан байдаг гэнэ. Ингэснээр авлигын гэмт хэргийн улмаас гадаадад гарсан хөрөнгийг буцааж авах ажиллагаа үр дүнтэй болдог гэхэд хэтийдсэн болохгүй.

“Өнөөдөр” сонин



**АТГ “АЧАА”-ГАА
ДИЙЛЖ БАЙНА УУ?!**

Сэтгүүлч Б.ДАМДИН-ОЧИР

Том хулгайн хэргүүд илрэхийн хэрээр АТГ-ын ачаалал нэмэгддэг. Ер нь АТГ “ачаа”-гаа дийлж байна уу. “Даац” нь хэтэрсэн гэхэд болно. Тиймээс ЦЕГ, ТЕГ-аас хүч нэмсэн ажлын хэсгийг байгуулж, мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэдэг. Нүүрсний хэрэг дээр гэхэд л энэ гурван байгууллагын 80 гаруй мөрдөгч нийлж ажиллаж байна.

Дээрээс нь өнгөрсөн долоо хоногт Засгийн газраас “...Авлигатай тэмцэх 5Ш арга хэмжээг авна” гээд зарлачихлаа. Энэ 5Ш арга хэмжээний хүрээнд АТГ-ын ачаалал улам нэмэгдэнэ. Тэгэхээр хэрэг бүр дээр гурван байгууллагын хамтарсан ажлын хэсэг гарч ажилласаар байх уу гэдэг асуулт гарч ирнэ. Уг нь АТГ, ЦЕГ, ТЕГ тус тусдаа тусгай чиг үүрэгтэй байгууллага л даа. Зайлшгүй шалтгаан, онцгой нөхцөлд хамтарсан ажлын хэсэг байгуулдаг. Тэгвэл цаашид ийм хэлбэрээр ажиллах хэргийн тоо нэмэгдэх тусам ЦЕГ, ТЕГ-ын өөрсдийнх нь чиг үүргийн ажлууд хойш тавигдахаар нөхцөл үүсээд байгаа юм.

Үүнийг шийдвэр гаргагчид олж харсан бололтой. АТГ-ын үйл ажиллагаагаа дангаараа гүйцэтгэх бололцоог хангаж, зарим өөрчлөлтийг хийхээр ярьж байгаа юм байна. Тодруулбал, АТГ-ын одоогийн бүтцэд өөрчлөлт оруулах, тэр дундаа орон тоо нэмэх замаар ачааллыг багасгах аж.

АТГ-ын ачааллыг буруулах арга хэмжээ авахдаа Мөрдөн шалгах хэлтэс, Тусгай хэлтэс, Гүйцэтгэх ажлын хэлтсийн алба хаагчдын тоог дориухан нэмэх гэнэ. Эх сурвалжийн мэдээллээр, тус газрын одоогийн мөрдөн шалгах, гүйцэтгэх ажлын алба хаагчдыг даруй 10 дахин нэмэх хувилбар ч яригдаж байгаа юм байна. Энэ асуудлыг хаврын чуулганаар хэлэлцэх бололтой.

“Зууны мэдээ” сонин